



**НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 19/25

Улаанбаатар хот

┌ Мөнгөн урамшуулал олгох тухай ┐

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, 52 дугаар зүйлийн 52.2, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт, 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Эмнэлгийн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.6.3, Хөдөлмөрийн дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.6.1, 2.6.3-д заасныг үндэслэн ТУШААХ нь

1. Нэгдсэн эмнэлгийн ажилтанд ажлын үр дүн гүйцэтгэлийг харгалзан “Үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох журам”-ыг нэгдүгээр, “Ур чадварын нэмэгдэл олгох журам”-ыг хоёрдугаар, “Тасаг, албадын ажилтны үр дүн, ур чадварыг дүгнэх ажлын хэсэг, хянах баг бүрэлдэхүүн”-ийг гуравдугаар, “Үр дүнгийн мөнгөн урамшуулалд удирдлага, хянах багаас нэмэлт үнэлгээ өгөх хуудас”-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Тасаг албадуудын ажилтны ажлын гүйцэтгэлийг сар бүр шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэх ажлыг ахлан хугацаанд нь хүлээлгэн өгөхийг тасгийн эрхлэгч, албадын дарга нарт, дүгнэсэн үнэлгээг хүлээн авч тооцохыг ажил дүгнэлтийг хянах багийн нарийн бичгийн дарга (Ж.Мөнхнаран)-д, явцын хяналт үнэлгээг хийхийг Эмнэлзүй эрхэлсэн орлогч дарга (Д.Сүнжидмаа), Халдвараас сэргийлэх хяналтын албаны дарга (А.Дэлгэрбаяр), Сувилахуйн албаны дарга (С.Энхцэцэг) нарт, сар бүр ажил дүгнэсэн үзүүлэлтийг хянан баталгаажуулж улирал тутам даргад танилцуулж үр дүнгийн болон ур чадварын мөнгөн урамшуулал олгуулах ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлын албаны дарга, багийн ахлагч (Д.Зулаа) -д тус тус даалгасугай.

3. Үр, ур чадварыг дүгнэсэн оноог харгалзан урамшууллын нэмэгдлийг үндсэн цалингийн хувиар хянан тооцож олгохыг Санхүүгийн албаны дарга (Ж.Баяомагнай)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эмнэлгийн даргын 2021 оны А/68 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын албаны дарга (Ш.Батбилиг)-д үүрэг болгосугай.

ДАРГА


Ц.ОЛОНБАЯР



3180710039

120

Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлгийн даргын
2022 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн
1/25 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт



ҮР ДҮНГИЙН МӨНГӨН УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Нэгдсэн эмнэлгийн ажилтанд ажлын үр дүн, гүйцэтгэлийг харгалзан мөнгөн урамшуулал олгохтой холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2 Мөнгөн урамшуулал ба нэмэгдлийг тус эмнэлэгт ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтан, үйлчилгээний ажилтнуудад олгоно.
- 1.3 Нэгдсэн эмнэлэгт ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтанд олгох нэмэгдэл, мөнгөн урамшилд шаардагдах хөрөнгийг байгууллагын төсөвт жил бүр тусган батлуулж байна.
- 1.4 Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг харгалзан сар бүр тооцож, улирал тутам олгоно.
- 1.5 Урамшуулал олгоход Төрийн албаны тухай хуулийн 51, 52 дугаар зүйл байгууллагын хамтын гэрээ, дотоод журам, Засгийн газрын 5 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулна.

ХОЁР. МӨНГӨН УРАМШУУЛАЛ ОЛГОХОД БАРИМТЛАХ ҮНЭЛГЭЭ, АРГАЧЛАЛ

- 2.1. Нэгдсэн эмнэлгийн эмч, сувилагч тусгай мэргэжилтэн, ажилтны гүйцэтгэлийг сар бүр шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэнэ.
- 2.2. Нэгдсэн эмнэлэгт хөтлөгдөж байгаа бүртгэл тайлангийн маягт, анхан шатны маягт, байгууллагын дарга, орлогч болон албаны дарга нар, тасгийн эрхлэгч, ахлах сувилагчийн үүрэг даалгаврын биелэлт, олон нийтийн ажлын бүртгэл, яаралтай түргэн тусламжийн дуудлагын журнал, жижүүрийн мэдээний дэвтэр, дотоод хяналт, өргөдөл гомдлын бүртгэл, алдаа болон сайн туршлагын сан, эмнэлэг магадлалын журмын эмчлэн эрүүлжүүлэлт зэргийг түүвэрлэн авч ажил дүгнэх шалгуур үнэлгээ өгнө.
- 2.3. Нэгдсэн эмнэлгийн эмч, сувилагч тусгай мэргэжилтэн, ажилчдын ажлын гүйцэтгэлийг сар бүр шалгуур үзүүлэлтийн дагуу ажил дүгнэх комисс 0-5 баллаар дүгнэнэ.

5 оноо тухайн ажлыг маш сайн гүйцэтгэсэн

4 оноо тухайн ажлыг сайн гүйцэтгэсэн

3 оноо тухайн ажлыг бүрэн гүйцэтгэсэн

2 оноо тухайн ажлыг хагас гүйцэтгэсэн

1 оноо тухайн ажлын гүйцэтгэл эхэн шатандаа байх

0 оноо тухайн ажлыг гүйцэтгээгүй байх

2.4 Нэгдсэн эмнэлгийн ажилтны ажлын гүйцэтгэлийн үр дүнг сар бүрийн 1-2-нд шалгуур үзүүлэлтийн дагуу тасгийн эрхлэгч, ахлах сувилагч, тасгийн чанарын багийн ахлагч дүгнэн хурлын тэмдэглэл нэгтгэлийг гарын үсгээр баталгаажуулж, сар бүрийн эцэст үнэлгээг нэгтгэн дүгнэж өгнө.

2.5 Тасгийн эрхлэгч, албадын дарга нар ажил дүгнэсэн үзүүлэлтээ сар бүрийн 3-ны дотор хянах багийн нарийн бичгийн даргад ажилтан бүрээр хүлээлгэн өгч гарын үсгээр баталгаажуулна.

2.6 Албадын дарга, тасгийн эрхлэгч болон ахлах сувилагч нар сар бүрийн 4-ны дотор ажлаа шалгуурын дагуу холбогдох орлогч дарга болон албаны даргаар дүгнүүлнэ.

2.7. Орлогч дарга нар эмнэлгийн даргаар ажлаа дүгнүүлнэ.

2.8 Эмнэлгийн дарга нь Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргаар дүгнүүлнэ.

2.9 Тасаг, албадын ажил дүгнэсэн үнэлгээг хянан баталгаажуулж дүнг хянах багийн ахлагч нэгдсэн эмнэлгийн даргад танилцуулна.

2.10 Нэгдсэн эмнэлгийн дарга тухайн улирлын хэлэлцсэн үр дүнг баталгаажуулан тушаал гаргаж олгоно.

2.11 Халдвар хамгааллын дэглэмийн шалгуур үзүүлэлтийг 0:5 гэсэн баллаар дүгнэнэ.

2.12 Ажлын үр дүнгийн үнэлгээнээс хамааран дараах хувь хэмжээгээр сар бүр мөнгөн урамшууллыг тооцно.

Бүх шалгуурын биелэлтийн хувь	Ажлын үр дүнгийн үнэлгээ	Албан тушаалын үндсэн цалингаас урамшил тооцох хувь (сард)
90-100	Бүрэн хангалттай	11-20 хувь
71-89	Хангалттай	10 хувь хүртэл

2.13 Мөнгөн урамшууллыг тухайн улирлын дараа сарын 15-ны (Санхүүжилт, эрх нээгдсэн тохиолдолд) дотор олгоно.

ГУРАВ. ҮР ДҮНГИЙН МӨНГӨН УРАМШУУЛЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохдоо:

1. Ажлын байранд ажил үүргээ гүйцэтгэж байгаа ажилтанд олгоно. Байнгын ажлын байранд шууд хугацаагүй хөдөлмөрийн гэрээ хийсэн ажилтанд олгоно.
2. Туршилтын хугацаа болон гэрээт ажилтанд олгохгүй.
3. Түр чөлөөтэй байгаа ажилтны оронд 6 сараас дээш хугацаагаар ажиллаж байгаа ажилтанд олгоно.
4. Чөлөөтэй, өвчтэй, ээлжийн амралттай байх хугацаанд мөн 1 сараас дээш хугацаагаар сургалтад явсан ажилтанд тус хугацааны үр дүнгийн урамшуулал олгохгүй.
5. Сахилгын арга хэмжээ авагдсан үед тухайн улирлын үр дүнгийн урамшуулал олгохгүй ба тухайн хугацаанд сар бүр ажлаа дүгнүүлсэн байна. Дүгнүүлээгүй тохиолдолд тасгийн чанарын багийн хурлын протоколыг

үндэслэн удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэн сахилгын хариуцлагыг нэмэгдүүлэн хариуцлага тооцно.

6. Ажлын үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлт 71-ээс доош хувьтай байгаа тохиолдолд тухайн албан хаагчдын улирлын урамшуулал олгохгүй.
7. Эмнэлэг үйлчилгээний дутагдал тооцогдсон тохиолдолд тухайн улирлын үр дүнгийн урамшуулал олгохгүй
8. Тухайн сар бүрийн 5-наас хойш ирсэн материалыг хүлээн авахгүй. Хоцроосон тасгийн эрхлэгч, албадын дарга нар ажилтнуудынхаа өмнө хариуцлага хүлээнэ.
9. Үр дүнгийн мөнгөн урамшуулалд удирдлага, болон хянах баг үнэлгээ өгөх хуудсаар оноог 60 хүртэл нэмэгдүүлэх болон дүгнэсэн онооноос хасаж хариуцлагыг сайжруулах эрхтэй.

Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлгийн даргын
2022 оны 01 дүгээр сарын 01-ны өдрийн
445 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт

УР ЧАДВАРЫН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

1. Сонгинохайрхан нэгдсэн эмнэлгийн алсын хараа, эрхэм зорилго, хөгжлийн хөтөлбөр, эмнэлгийн бие даасан байдлыг хангахад үр дүн, үр ашгийг тооцож, шинэ технологи, иноваци, нэвтрүүлсэн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлж, идэвх санаачлагатай ажилласан эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтан нарт ур чадварын нэмэгдэл олгоход журмыг мөрдөнө.

2. Ур чадварын нэмэгдлийг албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэдэг эмчлэх, сувилах, эм барих, эх барих мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн дагуу мэргэжлийн ур чадвартай, удирдлага зохион байгуулалт, дэмжих үйлчилгээний хүрээнд эрхэлсэн ажлаа тогтмол маш сайн гүйцэтгэсэн бусдад түгээн дэлгэрүүлсэн эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтанд энэхүү баримт бичгийн шалгуур үзүүлэлтийг баримтлан олгоно.

3. Эрүүл мэндийн ажилтанд ур чадварын нэмэгдэл олгоход дараах шалгуур үзүүлэлтийг харгалзана. Үүнд:

Шалгуур үзүүлэлт	Нийт үнэлгээний оноо
Төсвийн шууд захирагчтай байгуулсан хөдөлмөрийн гэрээ, гүйцэтгэл хариуцлагын гэрээний биелэлт нь "Хангалттай" төвшинд үнэлэгдсэн байх	70 оноо
Албан ажилдаа онцгой идэвхи санаачлага гаргаж, үр бүтээлтэй ажилласан, байгууллагын өмнө дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан.	
Мэргэжлийн ур чадвараа байнга өндөр түвшинд байлгаж, түүнийгээ бусдад зааж сургах талаар санаачлага гарган ажилласан байдал	
Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмаа биелүүлж эмнэлгийн ажилтны ёс зүй, харилцаа хандлагаараа хамт олноо манлайлж, хамт олондоо эерэг хандлага, баг хамтын ажиллагааг сайжруулахад сайн туршлага нөлөөллийг бий болгосон байдал, хамт олон сайшаан баталгаажуулсан байдал	30 оноо
Ажилтны мэргэжлийн ур чадвар, ажлын амжилт бүтээлийг нь мэргэжлийн байгууллага, үйлчлүүлэгчид нь сайшааж, үнэлсэн байх	
Өөрийн буюу удирдаж байгаа ажилтаны ажлын үр дүнг сайжруулахад тухайн албан хаагчийн оруулсан хувь нэмэр үр дүн урьд сар улирал жилээс ахисан байх	

4. Ур чадварын үнэлгээний бодох аргачлал:

- 80-85 оноо 10 хувь
- 86-90 оноо 15 хувь
- 91-95 оноо 20 хувь
- 96-100 оноо 25 хувь

5. Эрүүл мэндийн ажилтны ур чадварыг улирал болон хагас жил тутамд үнэлж, нэмэгдлийг сар бүр олгоно.

6. Шалгуур үзүүлэлтийн үнэлгээгээр 60,0 болон түүнээс дээш хувийг хангасан эрүүл мэндийн ажилтанд тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан ур чадварын нэмэгдэл олгоно.

7. Эрүүл мэндийн ажилтны ур чадварыг үнэлж дүгнэх, нэмэгдлийн хэмжээг тогтоох, нэмэгдэл олгох асуудлыг эмнэлгийн даргын тушаалаар байгуулсан хянах багийн санал, дүгнэлтийг үндэслэн даргын тушаалаар олгоно.

8. Ур чадварыг үнэлж дүгнэх, нэмэгдэл олгох үйл ажиллагаа нь ил тод, нээлттэй, шударга, хамтын оролцоог хангасан, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна.

9. Ур чадварын нэмэгдлийг тухайн эрүүл мэндийн ажилтны манлайлал, мэргэжлийн ур чадвараас өөр хүчин зүйл (эрүүл мэнд, амьдрал, ахуй нөхцөл байдал)-ийг харгалзан олгохыг хориглоно.

Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлгийн даргын
2022 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн
125 дүгээр тушаалын гуравдугаар хавсралт



ТАСАГ, АЛБАДЫН АЖИЛТАНЫ ҮР ДҮН, УР ЧАДВАРЫГ ДҮГНЭХ АЖЛЫН ХЭСЭГ, ХЯНАХ БАГ БҮРЭЛДЭХҮҮН

1. Тасаг албаны ажилтаны үр дүнг дүгнэх ажлын хэсэг

- Тасгийн эрхлэгч
- Ахлах сувилагч
- Тасгийн чанарын багийн ахлагч
- Албадын дарга

2. Хянах багийн ахлагч :

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлын албаны дарга

Нарийн бичгийн дарга

Хүний нөөцийн албаны дарга

Комиссын гишүүд:

Эмнэлзүй эрхэлсэн орлогч дарга

Бодлого төлөвлөлт хариуцсан орлогч дарга

Сувилахуйн албаны дарга

Санхүүгийн албаны дарга

Халдвараас сэргийлэх хяналтын албаны дарга

Инженер техникийн албаны дарга

Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлгийн даргын
2022 оны 01 дүгээр сарын 01-ны өдрийн
А/25 дүгээр тушаалын тавдугаар хавсралт

ҮР ДҮНГИЙН МӨНГӨН УРАМШУУЛАЛД УДИРДЛАГА ХЯНАХ БАГААС
НЭМЭЛТ ҮНЭЛГЭЭ ӨГӨХ ХУУДАС

№	Үзүүлэлт	Оноо нэмэх хасах хэмжээ
1	Жижүүрийн мэдээ өгөөгүй/ Хариуцлагатай жижүүрийн үүргийг гүйцэтгээгүй/	-5
2	Сайн дураараа ээлж сольж ажилласан	-5
3	Удирдах албан тушаалтнаас өгсөн цаг үеийн үүрэг даалгаврыг эсэргүүцсэн, биелүүлэхээс татгалзсан, биелүүлээгүй тохиолдолд	-5
4	Батлагдсан хуваарийн дагуу ажил үүргээ гүйцэтгээгүй дуудахад бэлэн байгаагүй, хугацаа алдсан	-5
5	Эмнэлзүйн алдаа гаргасан байдал/ Оношлогоо, эмчилгээ, тоног төхөөрөмж/	-10
6	Хугацаатай бичиг шийдвэрлэлт, тайлан мэдээг хоцроосон	-10
7	Хөндлөнгийн хяналт, үнэлгээнд хангалтгүй үнэлгээ авсан бол	-10
8	Яриа, цахим зөвлөгөөн, шуурхай, семинар, хурал хүндэтгэн үзэх шалтгаангүй ирцийн 30 хувь суугаагүй бол	-10
9	Ёс зүйн зөрчил гаргасан	-15
10	Анхан шатны бичиг баримт буруу хөтөлсөн, засварласан, хуурамчаар үйлдсэн	-15
11	Тухайн эмч, ажилчдын нэр дээр бичгээр болон Засгийн газрын 11-11-д гомдол ирсэн бол	-15
12	Үйлчлүүлэгчээс бэлэн мөнгө авч үйлчилсэн	-20
13	Төсөл хэрэгжүүлж ажилласан байдал	+10^15
14	Онцгой хүнд тохиолдлоос хүний амь нас аварсан	+10 ^20
15	Шинэ санаа, туршлага нэвтрүүлж ажилласан	+5^10
16	Эрдэм шинжилгээ судалгааны ажил хийж, мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн.	+10
17	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр тусламж үйлчилгээ болон нэгжийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хийж байгууллага хамт олноо манлайлж ажилласан байдал	+5^10
18	Албадын дарга удирдлагын өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь маш сайн гүйцэтгэж, ажлын байрыг эрсдэл, аюулгүй байдлыг хангасан эмнэлгийн тусламж үйлчилгээ болон үйлчлүүлэгчдэд ээлтэй байх нөхцөлийг бий болгосон	+10 ^20
17	Эмнэлэг хяналтын комисс, эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын хяналт, эмчлэн эрүүлжүүлэлт, халдварт бус өвчнийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа	+5 ^10
18	Ажлын үр дүнг буруу дүгнэсэн тохиолдолд	-15
	Ажлын хэсгийн гишүүд тус бүр Албадын дарга, тасгийн эрхлэгч тус бүр	-10 ^20